



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 415

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Монголын Үндэсний музейн албан хэрэгцээнд зориулан 18,000,000.00 (арван найман сая) төгрөгт багтаан автомашин олж авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Монголын үндэсний музейн захирал Д.Сүхбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000842

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 10 дугаар сарын 29 ны өдрийн  
.....415..... дугаар тогтоолын хавсралт



Монголын үндэсний музейн худалдан авах автомашины техникийн  
үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 8, хөдөлгүүрийн багтаамж 2500-3000 cc /улсын дугаар аваагүй/	ш	1	18,000,000.00
<b>Нийт дүн</b>			<b>1</b>	<b>18,000,000.00</b>
				<b>(арван найман сая)</b>